



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Баян-Агт сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2024/073/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Булган аймаг
2025 он

Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд
Тэргүүлэх аудитор: Ж.Энхцоодол
Утас: 7034-2580 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Г.Цэрэнлхам
Цахим хаяг: Tserenlhamg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	20
5.1 Төлбөрийн акт	20
5.2 Албан шаардлага	20
5.3 Зөвлөмж.....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХХААГ	Хүнс, Хөдөө аж ахуйн газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах/



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхлагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.02.24 № 280

танай _____ ны № _____ т

БУЛГАН АЙМГИЙН БАЯН-АГТ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Г.ТҮВШИНЖАРГАЛ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган аймгийн Баян-Агт сумын засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган аймгийн Баян-Агт сумын засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Төрийн жинхэнэ албан хаагчийн сул болон эзгүй байгаа орон тоог төрийн үйлчилгээний болон улс төрийн албан тушаалтнаар албан үүргийг түр орлон гүйцэтгүүлсэн,

Ажил олгогчийн санаачилсан шийдвэргүй, албан хаагчийн үндсэн ажлаа ажлын бус цагаар хийж гүйцэтгэж, илүү цагийн нэмэгдэл хөлс олгосон. ур чадварын нэмэгдлийг хийсэн албан тушаалтны хийсэн ажлыг үнэлж дүгнээгүй хавтгайруулан, цалингийн нэмэгдэл хэлбэрээр олгосон,

Ээлжийн амралтын биеэр эдлүүлэх боломжгүй талаарх нотлох баримтгүй, ажил олгогчийн шийдвэрээр нөхөх төлбөр олгосон,

Байгууллагын нэр дээрх арилжааны банкны дансаар хүчин төгөлдөр анхан шатны баримтгүй, зориулалт бусаар, төсвийг үр ашиггүй, үрэлгэн зарцуулсан зэрэг алдаа зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлаас хэтэрсэн байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул

632502539

байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Нэмэлт санхүүжилтийн төсвийг зарцуулах төсвийн эрх нээлгэхдээ Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан журмыг баримтлаагүй, тайлант хугацааны санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг бодит гүйцэтгэлээр илэрхийлээгүй, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас цалин, нийгмийн даатгалын шимтгэл, томилолт, хүнс, холбоо, шатахууны зардалд зардлын эдийн засгийн ангилал зөрчин, зориулалт бусаар зарцуулсан байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 8 зорилтын хүрээнд 69 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг аймгийн Засаг даргын 2024 оны А/794 дүгээр тушаалаар "маш сайн" үнэлгээ авсан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захиаргчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хязгаарлагдмал эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ЭНХЦОСДОЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

(мянган төгрөг)

	Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31.
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	235,391.37	208,891.67
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,981,315.02	4,076,953.75
	Нийт хөрөнгийн дүн	3,216,706.39	4,285,845.42
	Нийт өр төлбөрийн дүн	80.15	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,216,626.24	4,285,845.42
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,216,706.39	4,285,845.42
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,499,465.46	2,101,181.19
	Үйл ажиллагааны зардлын дүн	802,725.94	1,166,748.18
	Үйл ажиллагааны үр дүн	696,739.52	934,433.01
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	696,739.52	934,433.01
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,501,730.73	3,351,412.41
	Тайлант оны үр дүн	714,895.51	934,433.01
	Эцсийн үлдэгдэл	3,216,626.24	4,285,845.42
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	763,299.26	1,083,436.50
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	701,415.35	1,081,936.50
	Үйл ажиллагааны ЦМГ	61,883.91	1,500.00
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(61,874.70)	(1,500.00)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	992,947.40	972,416.01
	Урсгал зардал	992,947.40	972,416.01
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	992,947.40	972,416.01
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	992,947.40	972,416.01
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар санхүүгийн батламж мэдэгдлийн түвшинд нийт 25,647.8 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрсэнд, 25,647.8 мянган төгрөгийн 2 алдааг залрууллаа. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланд 20,531.4 мянга, нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайланд 3,760.5 мянга төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийг тус тус зардлаар тайлагнасан, хөрөнгийн зардал батлагдаагүй байхад 1,500.0 мянган төгрөгийн хөрөнгийн зардал тайлагнасныг хөрөнгө бэлтгэсэн зардалд тохируулга хийж залрууллаа,
2. Цалинг давтан тооцоолоход гарт олгох цалин таарсан боловч НДШ-ийн авлага 36.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг залрууллаа.

Аудитаар нийт 108,726.8 мянган төгрөгийн 6 зөрчил² илэрснээс, 15,941.5 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 14,373.6 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 78,411.7 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

Нийт илрүүлсэн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 91,120.0 мянган төгрөгөөр их тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Ажил олгогч ажилтныг илүү цагаар ажиллуулах шийдвэргүй, хамтын гэрээ, хэлэлцээр байхгүй, зориулалт бус, төсвийн шууд захирагчийн бүрэн эрхээ хэтрүүлэн албан хаагчдад нийтдээ 11,200.0 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.3, 103.3.4, Засгийн газрын 2019 оны 382 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ын 4, 5, 5.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.6-д "эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" заалтыг үндэслэн төлбөрийн акт тогтоолоо.

2. Сумын Засаг даргын орлогчид сумын Засаг даргын 2024 оны А/138 дугаар захирамжаар гамшгаас хамгаалах асуудал хариуцсан албан тушаалтны ажлыг хавсруулан гүйцэтгүүлэхээр шийдвэрлэж, үндсэн цалингийн 40 хувиар 748.0 мянган төгрөг, ЗДТГ-ын 2024 оны Б/04 дүгээр тушаалаар архив бичиг хэргийн ажилтнаар төрийн захиргааны мэргэжилтний ажлыг хавсруулан гүйцэтгүүлж 3,993.5 мянган төгрөгийн цалин тус тус олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 31 дүгээр зүйлийн 31.1, 42 дугаар зүйлийн 42.1, 43 дугаар зүйлийн 43.3.3, 43.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

¹Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 2.3.6-д “эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан” заалтыг үндэслэн төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

1. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй гэх нотлох баримтгүй, зориулалт бусаар 4,650.2 мянган төгрөгийн нөхөн олговрыг сумын Засаг даргын 2024 оны Б/27 дугаар захирамж, ЗДТГ-ын даргын А/25, 26 дугаар тушаалаар гурван албан хаагчдад олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.6 “Төсвийг зориулалт бусаар зарцуулсан” дахь заалтыг үндэслэн албан шаардлага хүргүүллээ.

2. Цалингийн зардалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхэд ур чадварын нэмэгдлийг үнэлж дүгнээгүй, хавтгайруулан гурван албан хаагчдад сар бүр 15-25 хувиар буюу нийт 9,723.4 мянган төгрөгийг зориулалт бусаар олгосон нь Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2019 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 3 дахь заалтыг хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.6 “Төсвийг зориулалт бусаар зарцуулсан” дахь заалтыг үндэслэн албан шаардлага хүргүүллээ.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Нэмэлт санхүүжилтийн данснаас зардлын эдийн засгийн ангилал зөрчин 210901 зардлаас 32,629.2 мянган төгрөгийн шатахуун, холбооны зардал, цалин, нийгмийн даатгал зэрэг зардлыг гаргасан байна.

Өгсөн зөвлөмж: Зардлыг бодитой төлөвлөж, Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж, үнэн зөв тайлагнаж хэвших.

1.2 Илрүүлэлт: Зургаан хөтөлбөрийн зардлын эдийн засгийн 4 ангиллаас нярвын Төрийн банкны 120101852855 дугаартай харилцах дансаар дамжуулан 45,782.5 мянган төгрөгийн бэлэн мөнгийг зарцуулсан байна.

Өгсөн зөвлөмж: Зардлыг бодитой төлөвлөж, төсөвт байгууллагын дагаж мөрдөх, нягтлан бодох бүртгэлийн бодлогын журмыг хэрэгжүүлэн үнэн зөв тайлагнаж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)																
Алдааны товч утга	Нийт алдаа			НББ-ын бодлогыг буруу хэрэгжүүлсэнтэй холбоотой			Буруу тусган илэрхийлсэн			Үүнээс				Зөвлөмж		
										Залруулсан		Залруулаагүй				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТГТ-д нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төвлөрүүлэх шилжүүлгийг тус тус зардлаар, хөрөнгийн зардал батлагдаагүй байхад хөрөнгийн зардлаар тайлагнасан.	1	25,611.8					1	25,611.8	1	25,611.8						
Цалинг давтан тооцоолоход гарт олгох цалин таарсан боловч НДШ-ийн авлага дутуу тайлагнасан.	1	36.0					1	36.0	1	36.0						
Дүн	1	25,647.8					1	25,647.8	1	25,647.8						

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил			Төлбөрийн акт			Албан шаардлага			Зөвлөмж			Хариуцлага тооцуулах албан шаардлага			Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Ажил олгогч ажилтныг илүү цагаар ажиллуулах шийдвэргүй, хамтын гэрээ, хэлэлцээр байхгүй, зориулалт	1	11,200.0	1	11,200.0													

